



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/1253

Улаанбаатар хот

“Гэрлэх ёслолын ордон” орон нутгийн  
өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын  
барилгыг акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/83 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1113 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон “Гэрлэх ёслолын ордон” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй нийт 52,388,930.77 (тавин хоёр сая гурван зуун наян найман мянга есөн зуун гучин төгрөг далан долоон мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Гэрлэх ёслолын ордон” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Ү.Оюунзул)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилга байгууламжийг буулгах, хоёрдогч түүхий эдийг зориулалтаар татан төвлөрүүлж 11,848,000.00 (арван нэгэн сая найман зуун дөчин найман мянга) төгрөгөөр худалдан борлуулж худалдсанаас орох орлогыг 70 хувийг буулгалтын зардалд зарцуулан, 30 хувийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийхийг “Гэрлэх ёслолын ордон” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Ү.Оюунзул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА  В.ОЮУМАА





אשר

הוא

הוא (א) - א

הוא

הוא

הוא

הוא

הוא

הוא

הוא

הוא



הוא (א) - א

הוא (א) - א

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/13 дугаар тушаалын хавсралт

ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт	Хоёрдогч түүхий эдийн үнэлгээ
1	Их өргөө гэр	12	ш	1	35,067,680.77	35,067,680.77	7,517,016.48	27,550,664.29	Нийслэлийн Хяналт, шалгалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02-13-01/082/217 дугаартай Улсын байцаагчийн дүгнэлтээр Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын хэрэгжилтийг тус тус хангахгүй байна гэж дүгнэсэн.	8,500,000.00
2	Гараж	30	ш	1	9,821,250.00	9,821,250.00	5,807,600.35	4,013,649.65		3,348,000.00
3	Усан оргилуур	15	ш	1	7,500,000.00	7,500,000.00	7,500,000.00	0		-
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					52,388,930.77					11,848,000.00